

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ОРЧУУЛГААР  
УГААГДСАН ХӨЛӨГ МОРЬД

Ж. Лувсандорж\*

**Хураангуй:** Монголын Нууц Товчоонд морийг түүний зан чанар, эрдэм чадал, гоо сайхны үнэлэмжээр нь нэрлэсэн хөлөг морьдын нэрсийг анхны хятад орчуулгад морины ердийн зүсний нэрлэлт болгож утга санааны ноцтой эвдрэлд оруулсан. Энэ нь хожмын европ хэлнүүдийн орчуулгын үндэс болсныг энэ өгүүлэлд шүүмжилж байна.

**0. Оршил**

Морь бол монгол үндэстний түүхийн гоц үзэгдэл (феномен) юм.

*«Онон голыг савд*

*Хур шиг шаагих адуунаас*

*Онгон хоёр Загалыг*

*Мөнгөн хяруунд сойсон юм»* гэх Д. Пүрэвдоржийн Чингис хаан шүлгийн мөрүүд бол тэдний «морин сэтгэлгээний» эрчим хүчийг оргилуулна. Хэрлэн, Онон, Туул - Гурван голын савд шаагьсан тэр их сүргийн дотор «Тэнгэр Хангайн заяагаар төрсөн» хурдтан, хүчтэн, эрчимтэн морьдыг сонгон шигшиж, дасгалжуулан боловсруулж «Харуул», «Алхинч», «Манлай», «Мангуд» гэж нэршсэн тусгай цэргийн ангиудын хөлөг болгож байсан нь Монголын Нууц Товчоонд (МНТ) тодорхой билээ.

Чингис хааны байлдан дагуулалтын чухам эх сурвалж нь монгол морьдыг цэргийн хүчит зэвсэг болгосон Цэрэг-дайны шинжлэх ухаанд оршино. Энэ эрдэм ухааныг тэрбээр өвгөд дээдсээсээ уламжлан авч төгс төгөлдөр болгон хөгжүүлснээр агуу их ялалтад хүрэв. Монгол морины эрдэм чадал, монголчуудын цэрэг дайны бодолгод холбогдох олон сонин баримт сэлт МНТ-д байна.

Гэвч МНТ-ы монгол эхийн ташаа галиг ба эндүү орчуулгад угаагдаад монгол эхээсээ хол зөрүүтэй өөр үг болон хувирч уншигчдын гарт хүрч байгаа үг, хэлц, идиом, нэр томьёо арай олон байна. Уг монгол эхдээ хөлөг морины эрдэм чадлыг үзүүлж байгаа морины нэрс,

\* Карлын Их Сургууль

морины өнгө зүсний нэрлэлт болж, хөлөг сайн морь нь гүү болон хувирсан явдал бага алдаа мэт харагдавч монгол морин цэргийн бодолго, эрдэм ухааныг бүрхэгдүүлэн далдалж байх болохоор шүүмжлэн хэлэлцэх чухалтай биз ээ.

**Хөлөг морь** Монголчууд морьтон, морьч болсоор хэдэн мянганыг орхих хугацаанд морьдыг олон янзын зорилго чиглэлээр сонгон боловсруулах их мэдлэг ухааныг хуримтлуулав. Хүч, хурд, эр зориг, явдал гишгэдэл, гоо үзэсгэлэн зэрэг олон шинж чанараар бусад морьдоос хэтийдсэн морийг *хөлөг морь* гэж эрхэмлэн нэрлэнэ. Хурд хэтийдсэн морийг *Хурдан хуйв*, эр зориг хэтэрхийг *Орог-шунгал*, гоо үзэсгэлэн хэтийдсэн морийг *Дайр-бор* гэж нэрлэсэн жишээг МНТ-оос үзэж болно. Хүч хэтийдсэн морийг *Тэнхээт хөлөг* («Тэнхээт хөлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би!» гэсэн Б. Явуухуланы шүлгийн мөрөнд монгол хүний сэтгэл догдолно) гэнэ. Цэрэг дайны морьдын дотор *тэнхээт хөлөг* нэн эрхэмд тооцогдоно. Зохиолч В. Инжанашийн “*Хөх Судар*” хэмээх түүхэн романд ердийн морь, тэнхээт хөлөг хоёрын ялгааг уран сайхны хэтрүүлэлт аргаар дүрслэн бичсэнийг товчлон үзүүлбэл монголчуудын *хөлөг морь* гэдэг ойлголтыг танин мэдэхэд туслах биз ээ, үүнд:

*Чингис хаан, цэрэг эрсийн эр чадлыг шалгаруулах тэмцээн зохиож байна. Тэмцээний талбайн голд 16 барим (~160 см.) урт төмөр сум бүхий хүнд нум, тус бүр 100 жингийн (~50 кг.) хүндтэй хоёр дам илд тавьжээ. Тэмцээнд оролцох эр, тэр хүнд нум сумыг авч мориндоо үсрэн мордоод морины давхианд 800 нумны тэртээх байг харван онох, хоёр дам илдийг авч мориндоо үсрэн мордоод морины давхианд эргүүлэх, дээш шидэж барьж авах, бүжиглүүлэх зэргийн бэрх болзолуудыг давах ёстой аж. Хэд хэдэн эрэлхэг эрс, болзлыг хангаж баатар цол хүртсэний хойно сул цэргийн дотроос хүн хар гөрөөсний адил сүрхий муухай царайт нэг эр гарч ирээд нөгөө хүнд нумыг татаж 15 удаа харваж 8 сум оносны дараа, тэр өөрийн барьсан 100 жингийн дам илд ба нөгөө хоёр дам илдийг хамт баруун сугандаа хавчаад мориндоо үсрэн гарсанд зэвсэг ба хүнтэй гурав дөрвөн зуун жингийн хүндийг гэнэт морины дээр цохисон мэт ачсанд түүний тэр морь нь ерийн цэргийн морь тул нуруу нь хуга эчиж пагвайтал унав. Үүнд жонон Мухули өөрийн унах “Хар халзан-Хаадын шонхор” нэрт морион унуулсанд тэр эр, их л баярлан мөргөөд үсрэн гарч гурван хүнд илдийг цаасан илд мэт бүжиглүүэн дуусгаад тэр гурван илдийг зүүн сугандаа хавчиж довтлон ирж нэгэнтээ бөхиймөгц өөрийн үхсэн морио шүүрэн авч баруун гарын сугандаа эмээл хазаартай нь сугавчилж амандаа “Гачигдлыг хамтатгасан*

*Гагц хөлөг минь,*

*Зовлонг хамтатгасан*

*Жороо хөлөг минь,*

*Гавьяа бүтээхүйеэ чамайгаан үхүүлэв*

*Зориг бүтээхүйеэ чамайгаан алав!” хэмээн хэлсээр цэргийн талбарын гадна манхын довд аваачиж тавиад мориноос бууж эмээл хазаарыг салгаж гурвантаа мөргөөд эгж иртэл Тайцу (Чингис хаан) хэтэрхийеэ баясан хэн хэмээн нэрийг асуусанд тэр эр: “Мангуд аймгийн Хуйлдар гэгч мөн” гэжээ (56: 650-652).*

## **1. «Дарги-оготор-хонгор», «Орог-шунгал», «Хурдан-хувь» гэдэг морьдын учир (§ 90)**

### **1. 1. МНТ-ы нөхцөлдөлгө**

Тэмүжинийх (ирээдүйн Чингис хаан) есөн морьтой байв. Тэдгээрээс нэг оготор сүүлтэй туранхай шарга (**dargi oqodur qongqor**) морийг дүү Бэлгүдэй нь унаад тарвагачилахаар

явсан байв. Гэтэл морьт дээрэмчид ирж, гэрийн ойр бэлчээрт байсан найман морьдыг хөөж явав. Үдэш Бэлгүдэйг ирэхлээр Тэмүжин, түүний тарвагачилсан нөгөө ядранги шарга морийг унаж дээрэмчдээс найман морьдоо буцааж авахаар явав. Тэмүжин гурав хоног явж байтал түүний замд хээр хөдөө газар нэг [насанд] хүрмэл хөвүүн (Боорчи) адуун сүрэгийнхээ дотор гүү сааж байна. Боорчи, Тэмүжиний зовлонг ойлгоод шууд түүнд туслан бүүр хамт явахаар шийдвэрлэж, Тэмүжиний нөгөө муу морийг сүрэгтээ тавиулж Тэмүжинд *Орог шунгал* (*oroq singqula*) гэгч морийг унуулж, Боорчи өөрөө *Хурдан хувь* (*qurdun qubi*) гэгч морийг унаад хамт явцгааж, дахин гурав хоног давхиж дээрэмчдийн хүрээнд хүрч тэднээс морьдыг чөлөөлөн авч чадав. Дээрэмчид хөөж сум тавилцсан боловч Тэмүжин Боорчи хоёр, хурдан хөлөг сайн морьтой байсан тул тэд гүйцэж чадсангүй.

**Морьдын нэрний хам бичвэр (контекст)** Тэмүжин найман сайн морио дээрэмчдээс буцаан авахаар амь өрсөлдсөн үйлст зорьж явахад Наху-баяны хөвүүн Боорчи, түүний ядарсан *дарги* морийг орхиулж, Тэмүжинд довтлон шунгагч эрдэмтэй сайн хөлөг морь - *Орог шунгалыг* сонгож өгөөд өөрөө *Хурдан уургач* морио унаж хамт явсан тухай энд ярьж байна. Амь өрсөлдсөн тэмцэлд морины чадал чанар хэрэгтэй болохоос өнгө зүс ямар хэрэг болох вэ, ямар найр наадамд явж байгаа биш! Хам бичвэрийн утга чухал юм. Морины нэрсийг өнгө зүсээр тайлбарласан хятад хадмалын эндүүрлээс («орог» гэдгийг *хар голтой*, «singqul» гэдгийг *цагаан /цайвар*, «qurdun qubi» гэдгийг *хурдан хул болгосон*) гарах арга нь бичвэрийг хятад орчуулгаас биш, уг эх монгол хэлнээс нь орчуулах хэрэгтэй биз ээ.

## 1. 2. Хятад (даймин) орчуулга

- *oqodur dargi qongqor*: хят. хадмалд *oqodur* гэдгийг *богино сүүл*, *dargi* гэдгийг орчуулгагүй орхиж, *qongqor* гэдгийг *шарга морь* гэж орчуулав.

- *oroq singqula*: хят. хадмалд *oroq* гэдгийг *хар голтой /хар нуруутай*, *singqula* гэдгийг *цагаан морь* гэв.

- *qurdun qubi*: хят. хадмалд *qurdun* гэдгийг *хурдан*, *qubi* гэдгийг *шар өнгөний нэг төрөл-цайвар шарга* гэв.

## 1. 3. Хэл-соёлын тайлбар

### 1. 3. 1. Морины нэр: *dargi oqodur qongqor* (Дарги оготор хонгор § 90. 6)

а) *dargi* гэсэн үг бол *dar ki-* (дар хий-) гэсэн дүрслэх үгнээс ирсэн, нэр ба үйлийн хосмол үндэс юм. Аливаа юмны эдэлгээ удтал давтагдахад тэр юм (мал, эд юм, хүн) ядранги, элэгдмэл байдалд орсныг үл таалах модалтай дүрслэх үг болно. Морины өнгө зүс, бие байдлыг заасан үг биш, моринд хандах хүний сэтгэлгийг заасан баймж (модал) үг юм. Ерөнхий модал санаа нь: *тааламжгүй, хүсмээргүй, улиг болсон*. Тусгай модал санаа нь: морины харагдах байдал - *эцэнги ядранги, хашин хойрго шиг*; явдал гишгэдэл - *хатуу, дар дар хийсэн морь* гэсэн мэдрэмжийг өгнө. Ойролцоо үг нь *туранхай-янхигар, өрвөгөр*. Би энэ үгийг малчин информатораас асууж үзэв:

- Дамдинжав гуай минь, *дарги хонгор морь* гэвэл та ямар морь гэж бодож байна?

Л. Дамдинжав (Архангай аймагийн Цэцэрлэг сумын Чулуут баг, нас 84, 2008 он):

- Унаанд талхиулаад бүүр *даргиж* хоцорсон морь л байдаг байгаа даа. Манай энд Даргиа Жамбал гээл архи даалуу хоёрт *даргиж* гүйцсэн нэг эр байсан даа, чи ч танина даа. Хүн ч тоохгүй, өөрөө ч тэрнийгээ юман чинээ санахгүй явж байгаад л өнгөрсөн дөө. Хонгор гэдэг ч яахав дээ, хул шаргал зүс... .

Малчны энэ ярианаас үзвэл *дарги* гэдэг үгийг тэд үндсэндээ ойлгодог, хэл яриандаа хэрэглэдэг үг ажээ. МНТ-ы хятад хадмалд энэ үгийг орчуулгагүй орхисон тул гадаад хэлний орчуулагчид түүнийг дагалдаж орчуулгагүй орхих юмуу зарим нь *dargi* гэсэн монгол үгийг үлдээж, ордос аялгууны *t'argi* 'богино (үс ба өвс ногооны тухай хэлэх)' гэсэн үгтэй холбож үзсэн Мостэртийн тайлбарыг үндэс болгон *богино үстэй, тачир үстэй* гм. орчуулах болов.

б) *oqudur* гэсэн үг бол *оготор* (утга нь *богино*, модал санаа нь *тааламжгүй*): *оготор* сүүл, *оготор* дээл, *оготор* морь (тааламжгүй богино сүүлт морь) гэх ойлгомжтой үг. Гэвч зарим хүн *үсгүй сүүл* (hairless tail, 10: 5, 6, 29) гэж орчуулав.

в) *qongyor* (хонгор) - цайвар хул зүсэм, манхан элсний өнгө адил (51: 159).

Жич: одоогийн нүүдэлчин монголчуудын гоозүйн сэтгэлгэд морины урт (борви давсан) өтгөн сүүлтэйг эрхэмлэнэ. Богино сүүлт морь ер нь тэдэнд таалагдахгүй тул *оготор, оодон, годил, шодон* гм. доромж үгээр дүрсэлнэ. Үсгүй сүүлт морь гэж ер нь байхгүй. Энэ бичвэртхи хонгор морины *дарги-оготор* гэсэн тодотголоос *хөөрхий өрөвдөлтэй морь* гэсэн сэтгэгдэл монгол хүнд төрөгдөнө. *Dargi* гэдэг дүрслэх үгний утга санаа орос хэлний *надоедливый*, англи хэлний *bothersome, troublesome* гэх үгстэй ойр очих болов уу.

### 1. 3. 2. Морины нэр: *oroq singqula* (Орог-шунгал § 90. 18)

**Орог-шунгал** - *хоршоо үг, морины нэр* (морины зан чанарын нэрлэлт), орог-шунгал (орогч-шунгагч, довтлогч, шунган дайрагч, ирмүүн хөлөг).

а) *oroq* (*со-мо. огуу, ха. орог*) гэсэн үгийн бүтэц нь *ору-* (үйл үг, *орох*) + *-у* (тэмдэг нэр ба жинхэнэ нэр бүтээх дагавар); үг үүсгэлийн адил загвар: *шуна-* – *шунаг, сэргэ-* – *сэргэг, бээрэ-* – *бээрэг, хари-* – *хариг*; *Орог* гэдэг бол морины урагш довтлон тэмүүлэх (оромтгой) зан чанарын нэр юм. Хүзүүгээ сунгаж гүрийн урагш хатирах зантай морь байдаг билээ. *Орог* гэдэг үгийн ойролцоо үг нь *шунгагч, шунгал* (доор үзэмүү), *орог шунгал* (хоршоо үг), *довтлогч, дайрагч*.

Жамуха, Бөртэ-Үжинийг чөлөөлөх дайнд бэлэн болсноо мэдээлсэн сүртэй үгэнд: *Орог-хурданаан унав би, Үдээст хуягаан өмсөв би...* гэв. Жамуха, шунган довтлогч хурдан хөлгөө унажээ гэж ойлгогдоно. *Ороу* гэсэн үгийг хятад хадмалд *хар голтой / хар нуруутай* (зүс) гэв. Үхэлдэхээр мордоход морины өнгө зүс ямар хэрэг байх билээ. *Ороу* гэсэн үгийг морины зүсээр тайлбарлах эндүүрэл ингэж МНТ-ы анхны хятад орчуулгаас эхлэв.

Жич, *Орог* гэсэн үг, зарим мал амьтны өнгө зүсмийн нэрэнд тохиолдоно. “*Хорин нэгт*” хэмээх тайлбар тольд (1717) *бодонгийн зүсний адилаг орог хэмээмүй* (31: 115) гэв. Морины зүсмийн нэрэнд бараг тохиолдохгүй (утгын зүйл хуваасан Таван хэлний тольд *Морь малын зүсний зүйл* гэдэгт 32 зүс тоочсонд байхгүй, 45: 4339-4348), ямаа, үхэр зэрэг амьтны зүсэнд гарна. Хэрэв орог зүст морь байж гэмээ нь монголчуудад таалагдахгүй тул эрхэм хүний (жишээ нь Тэмүжиний) унаа болгохгүй ба бэлэгт өгөхгүй. *Орог* гэсэн үгийг бас §24, §90, §106, §193 үзэмүү.

б) *singqula* < *singyu-* > *шунга-*; Энэ үг *ус зэрэгт шумбах, шурган орох, ж. шунгадаг завь, бүргэд шунгах* гэсэн тайлбартай (18: 860). Үгийн бүтэц: *singyu-* (үйл үг) + *-l* (тэмдэг нэр

бүтээх дагавар) - *singyul* (шунгал, шунгаач, шунгалган). *Орог шунгал* (*хорш.*) - шунган орох зантай морь (үзэмүү § 193) гэнэ. Наху-Баяны хүү Боорчи, Тэмүжиний нөхөр болж морьдын дээрэмчидтэй үзэлцэхээр явахдаа Тэмүжинд нисэн довтлогч хөлөг - Орог шунгалыг унуулсан (§ 90) ажээ! Амь өрсөн тулаанд явахад морины өнгө зүс ямар хэрэг болох аж. Хятад хадмал дахь *хар нуруутай цайвар морь* гэсэн ноцтой алдаа, орчуулгуудад давтагдсаар байна.

**Жич:** латин галигийн тухайд Рахевилц *singqula* гэж, Куракичи *šinyula* (§: 24. 2, 193. 6), *šinqula* (§ 90. 18) гэж хоёр янзаар галиглав. Монгол эхээс *šinyula* (шунгал) гэж галиглах нь зөв болно. *Singqula* гэсэн галигийг одоогийн монгол хэлээр *шунхал* гэж унших тул буруу тайлбарт хөтлөв. Монгол хэлэнд *шунхал* гэх морины зүс байхгүй! Тийн атал самгарид хэлнээс *шунх* гэх улаан будгийн нэр 17-р зуунаас хойш ламын шашны утга зохиолоор дамжин ирсэн (шунхан Ганжуур гм.) тул түүнтэй холбож уг морийг *зээрд* (улаан) гэж эндүү тайлбар хийсэн судлагчид бий.

Түүнээс гадна, *šinyulaqan morin* (Ку. § 193. 27), *singqulaqan morin* (Ра.) гэж галигласан үг бол монгол хэлний *шунгалган морь* (одоогийн хэлэнд ч байна: довтолгон морины нэрлэлт) гэсэн үг юм. Хэрэв *-уан* дагаварыг *-qan* дагавараар солибол багасгах утга орж утга санаа нь эвдэрнэ. Дундад үеийн хэлэнд ч энэ хоёр дагаварын дуудалга ялгарч байсан гэж бодож байна.

Тийм ирмүүн, шунгал морийг монголчууд одоо ч эрхэмлэн байдаг. Монголчуудын их дуртай нэг зохиолын дуунд:

«Харцагын шунгах ирмүүнээр

Хадан халилд цойлохдоо

Хаа ч хүрэх эрчээрээ

Хатан туурай нь баараагүй»... (дуу: *Зандан шоо*, Ж. Бадраагийн үг, Г. Бирваагийн ая)

гэж одоо ч дуулсаар байна.

### 1. 3. 2. 1. Гол даарьт годил сүүлт Орог-шунгал (§ 24)

Чингис хааны 10 дахи өвгө Бодончорын ганц морины нэрийг *γol dāyāritu γodoli segültü oroγ šinyula* (Гол даарьт годил сүүлт Орог-шунгал) гэх (§24.2). Энэ морины чимэлгэн тодотголыг орчуулагчид *нуруундаа шархтай, богино сүүлтэй* (зарим нь *даахирсан сүүлтэй*, зарим нь *сүүлэндээ үсгүй*) гм. орчуулдаг. *Даарь* гэгч нь эмээл тохомд холгогдсон шархны нэр мөн боловч удалгүй эдгэж шарх байсан газар нь цагаан үс урган сорви тогтсон нь морины тэмдэг мэт болж бас л даарь гэж нэрлэгдэх тул *гол даарьт* гэдэг нь заавал шарх байх албагүй, даарийн сорвийн нэр бас байх боломжтой юм. *Годил сүүл* гэгч нь сүүлний уг шингэн, үзүүрт нь нэлээд өтгөн (болцуут /годил сум мэт дүрт) үстэй богино сүүлний метафор нэрлэлт юм. Бас *туγ сүүл* гэнэ. Сайн морины шинжийн судруудад зааснаар бол « сүүлний хамаг мах (*мет.* үс) богиныг таалаюу. Бүдүүн болоод богино бол эрхэм, нарийн болоод богино бол дундаж, сул болоод урт бол адаг (шингэн ба урт бол муу)» (50: 158) гэж бий. Үүнээс үзвэл Бодончорын тэр морь бол хөлөг морины шинж бүрдсэн *Орог-шунгал* байсан юмсанжээ.

Сайн хөлөг морины дүр байдал голдуу эвгүй тааламжгүй байдаг, «үзэхэд муухай бөгөөтөл морь мориноос илүү гарна» (50: 144) гэж цохон заадаг байна.

### 1. 3. 3. Морины нэр: *qurdun qubi* (Хурдан-хувь § 90.19)

*Qurdun qubi* гэсэн үгийг хятад хадмалд *хурдан шарга морь* гэсэн болохоор бусад хэлнээ *хурдан ухаа*, *хурдан хул* гэх мэт үгээр орчуулж, *quba* гэсэн түрэг үг, түүний сүүлийн *ba* авиа нь *la* авиатай сэлгэж *qula* (хул) гэсэн үг болсон (6: 293 т 52) гэх зэргээр тайлбарладаг. Зарим судлагч эр хүйсийн *quba* (шарга морь) гэдэг үг, *i* дагаварыг авч эм хүйсийн *qubi* (шарга гүү) гэсэн үг болсноор тайлбарлаж орчуулсан нь бий (39:306). Наху-баяны ганц хүү, эр төрсөн Боорчи, гүү унаад дээрэмчидтэй үзэлцэхээр мордсон гэвэл монгол хүний санаанд багташгүй билээ. Ядуу хүнийг доромжлох хэлц үгэнд “гүү унаатай, гүзээ хоолтой эр” гэж байдаг юм. *Qurdun qubi* гэдэг морины нэрийг монгол хэлнээс тайлбарлах хоёр боломж байна:

а) *qubi* гэдэг бол сонгодог сонгол бичигт *quyiba* (ха. хуйв) гэдэг үгний хувилбар бичилгэ юм (үз Лессингийн толь, ХУБИ-2, 17: 977 ба ХУИВА, 17: 982). *Qubi* (хуйв) бол ороо бусгаа морийг оосорлон барих хэрэгсэл юм. Эрт цагт адуучин эрс, эвхмэл урт хуйвийг (*qubi*) давхиа морин дээрээс шидэж ороо морины хүзүүнд оруулан татаж барьдаг байв. Хожим нь тэр хуйвийг богино үйлдэж урт модон уурганд гогцоо болгон бэхэлж тэрнийг морины хүзүүнд оруулан барьдаг болсон аж. Уургын тухай § 91-д үз). Тэгэхлээр *Qurdun qubi* гэдэг бол *хурдан уурга* (уургач хурдан) гэсэн морины нэр болно. Хурдан, тэгээд бас уургач (*Хурдан-хувь*) морь бол морьтон нүүдэлчдэд эрхэм чухал хэрэгцээний үнэт сайн морины тоонд багтана. Уургач морь хурд ба хүчээр ялгарахаас гадна эзэн хүн морийг уургалаад (хуйвлаад) татах цагт урд хоёр хөлөө жийн цахдаж, хойт хоёр хөлөө бохирсхийн хойш сууж эзэн хүнд хүч нэмж морийг хамтран таталцах зэргийн олон эрдэмтэй. Ингэхлээр *Qurdun qubi* гэдэг нэр бол морины зүсэнд хамаагүй, морины эрдэм чадлын нэр байна.

Монголын малчдын дотор их дэлгэрсэн «Морины шинжийн судруудын» заалтаас үзэхэд сайн хөлөг морины шинжид морины зүс оролцдоггүй! Морины зүсийг тусгайд нь «*өлзийтэй 15 зүс* гэж тоочоод энэ өлзийт өнгө хэнд ч зохино» (50: 123-124) гэж заасан байдаг нь нүүдэлчдийн этнографийн коммуникацид гоозүйн сэтгэлгээний өөр асуудал болно.

б) «Хүн морь хоёр, холын удам татдаг» (цэцэн үг). Удам татсан хурдан морийг *хурдан заяат*, *заяаны хурдан морь* гэлцэнэ. *Хувь*, *заяа* гэсэн үгс синоним ба *хувь заяа* гэх хоршооо үг болохоор *Хурдан-хувь* гэгч нь *Хурдан-заяа* гэсэн морины нэр байж болно. Гэвч би эхний тайлбарыг илүү тохиромжтой гэж үзнэ. «Эрдэнийн хүлэг – хүлэг морины шинж» хэмээх сударт: «*Хурдан-хувь* морины шинж – нүд нь хурц, чих нь шовх, сагагны үс нүцгэн, салмагүй шодон, үргэх цуцах цагт сайн» (50: 143) гэжээ [салма – сүүлний угтхи үс].

## 2. «Хар-хурдан» ба «Орог-хурдан» гэдэг морьдын учир (§ 106)

### 2. 1. МНТ-ы нөхцөлдөлгө

Мэргид аймгийн ноёдод булаагдсан Бөртэ охиныг чөлөөлөхөөр Тэмүжин, Ван-хан, Жамуха гурав, нэн даруй 40 000 цэрэг үүсгэж цахилгаан дайн хийхээр тохиролцов.

Жамуха өөрийн цэрэг хэдийнээ бэлэн болсон тухайгаа нөгөө хоёртоо сүр жавхлант яруу найргийн мөрүүдээр илгээсэн мэдээлэлд:

*Хар-хурданыгаан унав Би.*

*Хатангуу дээлийгээн өмсөв Би. ...*

*Орог-хурданыгаан унав Би.*

Үдээсэт хуягийгаан өмсөв Би. ... гэв. Энд *Хар-хурдан*, *Орог-хурдан* гэсэн хоёр чухал сайн морины нэр гарав. Одоогийн зарим монгол уншигч үүнийг үзээд: Жамуха хурдан морио уналгүй яах вэ, харин *хар*, *орог* морь гэсэн нь сонин юм, Жамуха овилгогүй хүн болохоор *хар*, *орог* зүсэнд дуртай байсан юм болов уу даа гэж гайхах нэгэн байх биз ээ.

## 2. 2. Хятад (даймин) орчуулга

*qara qurdun* гэдгийг хят. хадмалд *хар* (зүс), *хурдан морь* гэж;

*oroq qurdun* (Рахевилц. галиг) /*oroq qurdun* (Куракичи галиг) гэдгийг хят. хадмалд *хар нуруутай хурдан морь* гэж орчуулав. Хожмын гадаад хэлний орчуулгууд үүнийг давтав.

## 2. 3. Хэл-соёлын тайлбар

### 2. 3. 1. Морины нэр: *Qara qurdun* ( *Хар-хурдан* § 106), *Oroq qurdun* ( *Орог-хурдан* § 106)

а) *qara* Энэ үг энд *хар* өнгө зүсний утгаар биш, *жинхэнэ*, *үнэн*, *үнэхээрийн*, *угийн* гэсэн утгаар орсон юм. Энэ утгыг одоогийн ярианы хэлний *морины хар хурдаар ирэ-*, *машин тэрэг хар гүйхээрээ давхидаг зам* г.м. хэлц хадгалж байна. *Хар* (*qara*) гэдэг үг, өнгө зүсний утгаас гадна *хольцоогүй*, *дан*, *дагнан*, *цэвэр*, *цэврээрээ*, *бүхлээрээ* гэсэн үндсэн утга үзүүлдэг, бас тэдгээрээс шилжсэн олон сонин утга, идиом бүтээдэг үг юм. Энэ тухай толь бичгүүдэд тодорхой бус заадаг тул хэдэн жишээ үзүүлэх нь чухалтай биз ээ.

Жишээ: *хар ус* (цэвэр ус), *хар хөлс* (усан хөлс), *хар мах*, *хар шол* (өөхний хольцгүй мах, шөл), *хар хүү* (эмтэй хольцоогүй хөвүүн), *хар айраг* (хольцгүй айраг), *энэ хар борооноор* (энэ усан борооноор), *хар хурдаараа* (байдаг хурдаараа) г.м.

МНТ-ы даймин орчуулагч, *qara* гэдэг үгний энэ утгыг анзаарсангүй юмуу мэддэггүй хүн байсан бололтой.

б) *oroq* Нөгөө *oroq* гэдэг үг бол *орогч*, *шунган орогч* гэсэн утгаар байгаа морины нэр байна (үзнэ үү 1.3.2.а). Даймин орчуулагч *oroq* гэсэн үгийн энэ чухал утгыг мэдэхгүй байсан гэж үзнэ.

## 4. «Эсгэл-халиун» ба «Эвэрт-үнэгэн-цагаан» гэдэг морьд (§ 117)

### 4.1. МНТ-ы нохцолдолго

Тэмүжин 11 настай байхдаа Онон голын мөсөн дээр мөсөн шагаа харвах тоглоом дээр Жамухатай танилцаж анд бололцох ёс хийсэн. Тэр хоёр одоо насанд хүрч цэргийн ноёд болоод Мэргид аймгийн эсрэг дайнд хамтын ялалт байгуулаад эртний анд болсон ёсыг дурсч улам сэргээх ёслол хийж байна. Тэгээд Тэмүжин, Мэргидийн ноён Тогтоагаас олзолж авсан алтан бүс, *Эсгэл-халиун* гэдэг морийг Жамухад бэлэглэж, Жамуха хариуд нь: Мэргидийн ноён Дайр-Үсүнээс олзолж авсан алтан бүс, *Эвэрт-үнэгэн-цагаан* гэдэг морийг Тэмүжинд бэлэглэж байна (§ 117).

## 4.2. Хэл соёлын тайлбар

### 4.2.1. Морины нэр: *Esgel qali'un* ( *Эсгэл-халиун* § 106)

а) *esgel* (*халх. эсгэл*) гэдэг үгэнд хят. хадмал: *хэдэн жил унагалаагүй* гэсэн дутуу тайлбар өгөв. Тайлбарын төгсгөл дутуу болохоор судлагч нар а) хэдэн жил унагалаагүй [гүү байж таарна]; б) хэдэн жил унагалаагүй [гүүгээс төрсөн нь байж таарна]; в) хэдэн жил унагалаагүй [гүүгийн сүүг хөхөж өссөн сайн морь байх ёстой] гэх зэргээр таамнал тавьж түүнийгээ батлах баримтуудыг нутгийн аялгуунууд ба аман зохиолоос эрж хайв.

Орчуулагчид бол шууд л а) тааврын дагуу хэдэн жил унагалаагүй гүү гэж орчуулцгаасан билээ. Ийм орчуулгыг монгол хүн үзвэл гайхна, гайхахаар барахгүй дургүйцнэ. Яагаад гэвэл хаад ноёд, баатар эрс, цэрэг эрс гүү унадаггүй (*морь олон байхад гүү унаад яах вэ, тэгээд ч гүү холын аян даахгүй*). Энгийн малчин эрс ч найр наадам, баяр ёслолд гүү унадаггүй заншилтай билээ. Гүүг эмэгтэйчүүд унана, найр наадам, баяр ёслолд бас унахгүй. Эрэгтэйчүүд бол гүүг гэр зуур, түр унана.

Үр төл төрөхгүй амьтныг *эрмэг* гэнэ (18: 884). Эрмэг гүү хүч тэнхээ сайтай учир аян замд унахад зүгээр гэдэг. Хэрэв эрмэг гүүгээс унага төрвөл тэр нь хүчит сайн морь болдог гэх домог яриа байдаг. МНТ-ы монгол судлагч нарын бичсэн юмнаас үзэхэд *эрмэг* гэдгийг зарим аялгуунд *эсгэл* гэдэг бололтой юм. Тэгээд тэр *esgel*-ийг эрмэг гүүтэй холбож тайлбарлах болов.

*Esgel* үг ийм ээдрээтэй, толь бичигт тэмдэглэгдээгүй боловч сайн тайлбарыг Өвөрмонголын эрдэмтэн Б. Ванжил өгсөн байна. Тэрвээр «*эсгэл* гэж бөөрий нь авсан (агталсан, Лд.) морийг хэлдэг. Ерөнхийдөө морийг дөрвөн насанд нь агталдаг. Үүнийг зарим газар *үрээ эсгэнэ* гэдэг. Агталсан морийг *хайрмал морь*, *цагаалсан морь*, *хөнгөлсөн морь*, *эсгэл морь* гэж орон бүхэнд адилгүй хэлдэг гэж бичив (44: 112). Энэ тайлбар зүйтэй ажээ. Үгийн гарал нь *esge-* (*халх.* эсгэ- ~ огголо-, хэрчи-) гэсэн үйл үндсэнд *-l* (-л) дагавар залгаж бүтээсэн эерүүлэх мод санаатай нэр үг байна. Лу. Алтан Тсвчид «*Tere čerig-ün qarayul-dur Ongliyud-un Čayan, "tümen esegüi yary-a" gebe. Qayan jarliy bolba: "üriy-e mori qurdun bolbasu, kögsin morin qolači bui" geji.* (Тэр цэргийн харуулд Онлигуудын Цагаан, "түмэн эсэгүй (эсгэл) гарга" гэв. Хаан зарлиг болов: "үрээ морь хурдан боловч хөгшин морь холч буй" гэжээ (13: 142а) гэсэн бичвэр байна. Энд байгаа *esegüi* гэсэн үг, *esgel* болох нь хаан түүнийг *үрээ* гэж ойлгосноос тодорхой ажээ.

**b) qali'un** (*халх.* халиун) гэдгийг хят. хадмалд *биеийн хэсэг нь хар, газар шорооны өнгөтэй* гэж тайлбарлан орчуулсан нь морины зүс мөн гэж мэдэгдэнэ. Гэвч *qali'un* гэсэн үгний анхдагч утга нь илээд баймаар торгомсог зөөлөн үст *халиу* (*и*) гэгч амьтны нэр болохоор тэр морины үсний чанарыг онцолсон метафор нэр болно. Халиун гэгч зүсний одоогийн тайлбарыг 18: 650 үз.

#### 4. 2. 2. Морины нэр: *Ebertü ünügün сага'an* (Эвэрт үнэгэн цагаан § 106)

Хятад хадмалд *эвэртэй эр ишиг/хурга мэт цагаан морь* гэв.

**a) Eber** Моринд эвэр байхгүй тул амьтны эврийн дүр байдлыг санагдуулам үсний метафор нэрлэлт байх аа гэсэн бодол төрөгдөх үг болно. Морины гөхөлийг утсаар ороомоглон эвэр мэт болгосон чимэлгэ байж болох юм. Гэвч эргэлзээтэй. Ш. Гаадамбын тайлбар зөв бололтой. Тэрбээр «Бид энэ үгийг халхын малчдын ярианд сайн морь үсний хоёр эргүүлэгтэй байдаг гэх үг байдагтай холбож магнайн хоёр талд эргүүлэг нь өөдөө тугалмай эвэр мэт сөрвийсөн үстэй морийг *эвэрт* морь гэдэг байх гэж бодож байна. Учир нь хүүхдийн толгойн хоёр талд гээг ургуулахаар тавьсан хоёр тав үсийг эвэр гэж монголчууд ярилцдаг юм» (5: 307 т 408) гэв. Ингээд эвэр гэсэн үг бол зарим морины магнайдхи (сайн морины шинж гэгдсэн) эргүүлэг үсний метафор нэрлэлт мөн гэж үзнэ. Хят. хадмалд энэ үгийг *ишиг* гэдэг үгний тодотгол (*эвэрт ишиг*) гэж ойлгогдохоор болгосон нь утга тохирохгүй байна. *Эвэрт* гэдэг үг бол *ишиг* (*ünügen*) гэсэн үгний тодотгол биш, «*Үнэгэн-Цагаан*» гэсэн холбоо үгний тодотгол юм.

**b) Ünügün** гэсэн үг бол *ишиг* гэдэг үгний өөр нэр болох нь маргаангүй тогтоогдсон юм. Харин яагаад *ишгэн цагаан* гэсэн бэ гэдгийн тухайд бол «морио хайрлаж эрхэмлэж өхөөрдөж нэрлэхдээ *янзаган зээрд, туулай хүрэн, буган халиун* гэх зэргээр амьтан адгуусны дүр төрх, өнгө зүсээр үлгэрлэн өгүүлдэг» (6: 337 т 169) гэсэн итгэлтэй тайлбар байна. Тэгэхлээр нялх ишигний арьс мэт илээд баймаар зөөлөн таатай үст морь байжээ гэж ойлгож болно.

Тэмүжин Жамуха хоёр энэ удаа амь өрсөн тэмцэлт үйлст явах гэж байгаа биш, амар жаргалдах гэж байгаа болохоор морьдын нэрэнд гоо сайхны таашаалыг (халиуны ба ишигний торгон зөөлөн үс зүс) эрхэмлэсэн нэр сонгосон нь МНТ-ы зохиогчийн уран санаа биз ээ.

## 5. «Дайр-бор» гэдэг морь § 3

### 5.1. МНТ-ы нөхцөлдөлгө

Чингис хааны 16 дахи өвгө Торголжин-Баяны тодорхойлолтод байгаа морьдын нэр юм. *Торголжин-Баян, Борогчин-Гоо гэргийт, Боролдой-Соёлби залуут, Дайр-Бор хоёр хөлгүүд агтаст бөлгөө* гэсэн бичвэрт байна. Энэ бичвэр бол баян Хан хүний онцолбор (сайхан гэргийтэй, соёлт залуу хиатай, сайхан морьттой билээ) юм. Энэ бичвэрээс *Дайр-Бор* гэгч онцгой сайхан морь байж таарна гэх сэтгэгдэл төрөгдөнө.

### 5.2. Хятад (даймин) ба европ орчуулга

**Dayir Boro** (*халх.* Дайр-бор) гэсэн үгсийг хятад хадмалд үг тус бүрд *морины нэр* гэсэн тайлбар өгч, зүйлийн эцэстхи товч орчуулгад *нэг нь Дайр, нөгөө нь Бор гэсэн нэртэй хоёр морь* гэж орчуулав. Европ хэлнүүдийн орчуулагчид хят. хадмалыг анхаарсхийн голдуу морины зүсээр (Козин: *две скаковые меринь-Дайир и Боро*; Кливз: *two noble geldings, Dayir and Boro*; Рахевилц: *two fine geldings, Dayir and Boro, I.e., 'Dusky' and 'Grey'*; Поуха: *dva ušlechtilé hřebce, Světlehnědého a Tmavohnědého*) орчуулав.

### 5.3. Хэл-соёлын тайлбар

Зүй нь: *Дайр-бор* (Буган-халиун) *гэгч алдаршил нэртэй, хоёр хөлөг морьтой бөлгөө* гэж орчуулбал таарах байжээ. Морь нэрлэх загвар нь хожим Чингис хаан бас «*Эр хоёр Загал*» гэгч алдаршил нэртэй, хоёр хөлөг морьтой байсан гэж хуучин үеийн уран зохиолд магтан дуулдагтай адил байна.

Үгийн гарал: *dayir/dayir* (дайр/тайр - эр буга, 18: 180, 515), *bor* (бор - халиуны зулзага, 18: 93) гэсэн хоёр үг нийлж *Дайр-бор* гэсэн морины нэр болсон байжээ. *Дайр-бор* гэдэг бол буга мэт өндөр гоолиг биетэй, халиу мэт зөөлөн торгон үстэй, ховор тохиолдох морины алдар-нэр байсан гэж үзнэ. Тэр нэр мартагдаж оронд нь одоогийн малчид *Буган халиун* гэх болсон нь чухамдаа *Дайрбор* гэдэг эртний нэрний аялгууны дүйцэл хувилбар ажээ. Бичвэрээс Торголжин-Баян Хан, гоо үзэсгэлэнт эхнэртэй, хоёр сайн хөлөг морьтой, соёлтой залуу хиатай байсан гэх онцолбор (isolation) тод мэдэгдэнэ. Морины бараан бор хоёр зүс монголын адуунд түгмэл, адуутай айл бүрд байх тул баян Хан хүнийг ийм зүсний хоёр морьтой байсан гэвэл амтгүй яриа болно. *Бараан* (dayir) *бор* хоёр зүсмийн морь гэсэн европ орчуулгууд таарахгүй байна.

Жич: *Дайр-бор* гэх нэртэй, овоо тахилгатай уул одоо байна. Хойт Тамир, Урд Тамир хоёр голын бэлчирт (нутгийнхан энэ газрыг *Гурван Тамир* гэнэ) түрж орсон жижиг боловч сүрлэг,

дэл хадтай ухаа уул (Архангай аймгийн Батцэнгэл сумын төвийн ойр) юм. Домог түүх нь тодорхойгүй. Торголжин-Баяны морьтой холбоотой газар бололтой. Монгол нутагт *Халиун морьт*, *Шарга морьт*, *Мөнгөн морьт* г.м. уулын нэр олон байхаас үзвэл *Дайр-бор* уулын нэр бас морины нэрээс ирсэн биз.

## 6. «Орогууд», «Мангууд» (§: 130, 209) гэдэг цэргийн ангийн учир

### 6.1. МНТ-ы нөхцөлдөлгө

Монголын морин цэргийн анги, бөлөг (түмт, мянгат, зуут) тус бүрд гурван хэсэг хүчин ялгарсан зохион байгуулалттай байв. Тэр нь **1)** туршуул хүчин (харуул, алхинч) - Чингис хааны үгээр: зорьсон газраа илгээх (*jorigsan qajar-a ilcju*, § 209. 8) хүчин, **2)** хошууч (манлай) хүчин - Чингис хааны үгээр: урдаа байлгах (*urida'an bayi'ulu'asu*, § 209. 12) хүчин, **3)** голын хүчин – Чингис хааны үгээр: дэргэдээ авах (*derge-de'en a'asu*, § 209. 10) хүчин – ийм гурван хүчин юм. Чингис хааны (голын хүчиний жанжин) хувьд бол тийм манлай хүчинийг *Орогууд* (орогчид, дайран орогчид) – (одоогийнхоор бол сөнөөгч онгоцнууд шиг л юм даа), *Мангуд* (мангад, мангас, мангадууд) – (одоогийнхоор бол танкийн хороо шиг л юм даа) гэж нэрлэж байв. Энэ хоёр аварга хүчтэн ангийн цэрэг эрсийн тухай МНТ-д:

«Тойрон бүслэх тутам

Тохь журам нь зохирдог

Дэрлэн дайрах тутам

Дэм хүч нь зохирдог

Өчүүхэнээсээ илд жаданд дассан иргэн тэд

Өр зүрхийг өвтгөх (сэрэлтэй) иргэн тэд» (§ 170) гэж эсрэг хүчний жанжин «үнэлэлт өгсөн» ба, олон удаагийн дайнд онцгой гавьяа байгуулсан энэ хоёр цэргийн анги, Чингис хааны цэрэг-дайны бодолгод ямар зэргээр үнэлэгдэж байсан нь хааны өөрийн нь хэлсэн үгэнд тов тодорхой илэрсэн нь:

«Хувилай Зэлмэ Зэв Сүвээдэй

Та дөрвөн нохосыгоон

Зорьсон газраан илгээж

Боорч Мухули Борохул Чулуун баатар

Эд дөрвөн хөлөгүүдийгээн дэргэдээн авбаас

Хатгалдаан өдөр болбоос

Жүрчээдэй Хуйлдар хоёрыг

Орогууд Мангудаараан урдаан байгуулбаас

Бүгд сэтгэлийгээн амуух бөлгөө би» (§ 209) гэжээ.

### 6.2. Орчуулагч судлагчдын галиг ба тайлбар

*Oroγud Mangγud* (Куракичи галигт *Uruγud Moγγud*, Рахевилц галигт *uru'ut mangqud*) гэдгийг хятад хадмалд *овог аймгийн нэр* гэв. Европ хэлний орчуулагчид уг нэрсийг *Uru'ut Mangγud*, *Uruut Mangchut*, *Уруут Манγут* гэж галиглаад өөр тайлбар өгсөнгүй. Монгол хэлний орчуулагчид *урууд мангудын цэрэг* (3: 188), *Уругууд Мангуд* (4: 107) гэж галигласан ба судлагч Ш. Гаадамба «*Уругуд* – овгийн нэр, *уруг* (худ ураг, Лд.) гэсэн үгний олон тоо, эсвэл *оруг-уд* (*саарлууд*) гэсэн үг байж ч бас магадгүй» (5: 241 т 126), «*Мангуд* – овгийн нэр, *монгол* гэдэг үгийн хуучин хэлбэрийг хадгалсан нэр» (242 т 127) гэж тайлбарлав.

### 6. 3. Хэл-соёлын тайлбар

#### 6. 3. 1. Цэргийн анги ба овгийн нэр: *Urujud /uru'ut* (Орогууд §: 46, 130, 209)

Энэ үгийг худам монгол бичгээс *orojud, urujud, oru'ud, uru'ud* гэж лав 4 янзаар унших боломжтой. Хятад галигчийн сонгон авсан *uru'ud* (урууд) гэсэн үг ба бас *oru'ud* (орууд) гэх үг тодорхой утга гаргахгүй. *Oroju* гэсэн үг 1. орог (орог зүс), 2. орог (орогч) гэсэн хоёр утга гаргана. *Uruju* гэсэн үг 1. *ураг* (худ ураг), 2. *ураг* (урагч, урж таслагч) гэсэн хоёр утга гаргана. Эдгээр дөрвөн утгасаас МНТ-ы өгүүлэмжийн хам бичвэрт тохирох утга бол *орог* 2 (орогч) гэсэн утга юм. Харьцуулж үзэмүү: «§ 90. 18: **орог** – *морины нэр* (орогч, довлон орогч, шунган орогч ирмүүн морь)» гэх цэрэг-дайны морины нэрийн шилжмэл утга: «дайран орогч морин цэрэгтэн» гэсэн утга бүхий алдаршмал овгийн нэр мөн гэж үзнэ.

Үгийн бүтэц нь *орог* (дээр ярьсан *орог-шунгал* морины тайлбарт үзэмүү) гэсэн үгэнд олон тооны *-ud* нөхцөд залгаж *ороjud* (орогууд/оргууд) гэсэн үг болжээ. Эртний монголын цэргийн бодолготонгууд, дайран орогч зантай морьдыг сонгож тусгай анги байгуулж дайнд манлай (хошууч) довтолгож байсан, түүнийг *ороjud* (шунган орогч анги) гэж нэрлэж байжээ.

Чингис хааны 7-р үеийн өвгө-авга Начин-Баатар нэг хүүгээ тийм орог цэргийн ноён болгосон нь гавьяагаараа алдаршиж түүний нэрийг орлон овгийн нэр болсон бололтой. Хожим нь энэ овгийн ноён Жүрчээдэй, уламжлалт орог цэргийн ангийг зохион байгуулж Жамуха Ханы хошууч болж Чингис хааны эсрэг довтолсон. Гэвч Жамухын цэрэг дайны бодолго учир утгагүйг мэдмэгц генерал Жүрчээдэй, Орогуудаан дагуулж шууд Чингис хаанд орж өгөв (§ 130). Чингис хаан, цэргийнхээ түмэн агтын дундаас орог-шунгал морьдыг сонгож, эр цэргийнхээ дундаас бас “орог-шунгал” эрсийг (дайран орогч зоригтон шонхорууд) сонгож түүний Орогуудыг улам бэхжүүлээд өөрийн урдаа барих хошууч хүчин болгосон юм.

Хожмын уншигчдын заримууд *ороjud* гэсэн үгийг худам монгол бичгээс *uruud* гэж урт эгшигт үг болгон ташаа уншсан байдал МНТ-ы хятад галиг ба Рашидын түүхнээс мэдэгдэнэ. Харин Лувсанданжин уг үгийг *оруjud* гэж бичээд хэдэн үгний дараа зориуд *оруjud* (13: 9а) гэж таслан бичсэн нь урт эгшгээр уншихаас болгоомжлуулсан үсэгзүйн арга ажээ. Жүрчээдэйн *Орогууд* олон дайнд хошуучилж онцгой гавьяаг олон удаа байгуулж өгсөн болохоор Чингис хаан «Жүрчээдэйг өндөр уулын нөмөр мэт сэтгэж явах бөлгөө би» (§ 208) гэсэн нь нүүдэлчдийн сэтгэлгээний эрхэм дээд үнэлэлт болно. *Orojud* гэдгийг *ургууд* гэж уншаад *ураг* (ураг худ) гэх үгтэй холбосон тайлбар ба *орогууд* (саарлууд) гэсэн таамналыг тохирохгүй гэж бид үзнэ.

#### 6. 3. 2. Цэргийн анги ба овгийн нэр *Manjud /Mangqut* (Мангуд /Мангад §: 46, 130, 209)

Эртний монголын цэргийн бодолгод байсан *Мангад* (мангас хүчтэн) гэгч онцгой ангийн нэр гэж үзэх нь МНТ-ы нөхцөлдөлгөд тохирч байна. Начин-Баатар нэг хүүгээ тийм мангад цэргийн ноён болгосон нь алдаршиж улмаар түүний уугуул нэрийг орлон, овгийн нэр болсон биз ээ. Хожим нь генерал Хуйлдар тийм анги байгуулж Жамухын цохих хүчин болж Чингис хааныг айлгах дайнд оролцсон боловч Жамухын овилгогүй бодолгыг танимагц түүнээс хагацаж Жүрчээдэйн хамт Чингис хаанд дагаж оров (§ 130). Чингис хаан, цэрэг агтынхаа дундаас хүчит хөлөг морьд ба бяр тэнхээтэн эрсийг сонгон хошууч ангийг дэдлэгч *хотөч* анги - *Мангудыг* цаашид улам бэхжүүлсэн нь мэдээж. Аман зохиол, туульсын мангар хүчтэний мангас /мангад (*mangyus /mangjud*) гэх нэрийн шилжвэр утга мөн гэж үзнэ. *Mangqut* хэмээх

үгний франц орчуулга үзэмүү (11: 333). *Орогууд Мангууд* хоёр ангийн тухай Чингис хааны бодол санаа ба үнэлэлтийг § 209-д үзэж болно.

Агт морьд ба цэрэг эрсийг Тэнгэрээс заяасан эрдэм чадлаар нь ялган шигшиж цэргийн тусгай анги байгуулж тэр агуу хүчтэн ангийн нэр нь хожим овог аймгийн нэр болон алдарших явдал бол эртний монголын цэргийн бодолгод бат тогтсон уламжлал байсан юм. *Жүрхин* хэмээх уур омогтой, чанга зүрхтэн овгийн гарлыг тодорхойлон заасан хэсэг (МНТ-ы 139) бол тэр уламжлалын сайхан жишээ байна.

## 7. Төгсгөл

Монголын Нууц Товчооны хятад эх гэгч бол 1) МНТ-ы уйгур-монгол бичгийн эхийг хятад галиг үсгээр (монгол хэлээр) буулгасан бичвэр, 2) Тэр бичвэрийн үг бүрийн хажуудхи хятад хадмал орчуулга, 3) Хэсэг (нийт 282 зүйл) бүрийн эцэст утгачилсан товч хятад орчуулга – ийм гурван хэсэг бичвэр бүхий ном юм. Энэ их бүтээлийг үйлдэгчид нь хятад газар төрж өсөж, хэл бичгийн эрдэмд боловсорсон Хау-юван-гэ (Хуяг?), Ма-ша-йике (Маш-их?) гэгч хоёр монгол эрдэмтэн гэх (6: 18-19).

«Хятадын профессор Ченг-юван МНТ-ы хадмал орчуулгыг судалж үзээд хааяа зарим нэг үгийг ор тас орчуулгагүй орхисныг (40 үг) ажиглаж Нууц товчооны орчуулагч урт удаан хугацаагаар дотор газар сууснаас хуучирсан монгол үгсийг хөрвүүлж чадаагүй байна» (6: 21) гэж үзжээ.

Түүнээс гадна, нууц товчоо судлалч Ш. Гаадамбын үзэлтээр «МНТ-ы хятад хадмал орчуулгыг хийсэн хүн нь түрэг хэлтэн хүн байсан болов уу гэж санагдуулмаар. Монгол хэлний үг, монгол түрэг хэлний дундын өдий төдий үгийг түрэг хэлний үгийн үүднээс утгыг тайлсан нь баримттай юм. Иймд өвөрмонголын эрдэмтэн Баяр гуайн [бичсэнээр] “Баруун орны балга хотын хүн Цагааныг Нууц Товчооны утгын орчуулагч болохоор барахгүй, авианы орчуулагч ч мөн” гэж үзсэн нь үндэстэй бөгөөд зөв санал болов уу гэж санагдаж байна» (5: 261-262 т 218) гэсэн нь анхаарууштай билээ.

Хадмал орчуулгагүй үлдээсэн явдал бол тийм ноцтой дутагдал биш юм. Монголын эрдэмтэн Д. Цэрэнсодном энэ тухайд «эргэлзээтэй үгсийг [орчуулгагүй] үлдээсэн нь энэ орчуулагчийн судалгааны байр суурийг тодруулах нэг баримт болж байна» (6: 22) гэж үнэлэв. МНТ-ы хятад галиг ба хадмалд үүнээс өөр ноцтой алдаа дутагдлууд цөөнгүй байгааг нухацтай судлах нь *Нууц товчоо судлалын чухал зорилт* болно. Үүнд,

- «хэтэрхий бүдүүвчилсэн орчуулга» (6: 20) олон байгаа (жишээ нь тэнгис – *усны нэр*, хавлан – *араатны нэр*, хулат – *шувууны нэр*, согосон – *загасны нэр* гм...гм.).

- эндүү ташаа орчуулсан (салаа олон утгат үгсийн тохирох утгыг олоогүй, омоним үгсийн тохирох утгыг олоогүйгээс буруу орчуулга болсон, метафорууд болон идиом хэлцүүдийг үгчлэн орчуулсан зэргийн ноцтой алдаа дутагдал арай олон болсон.

- Түүнээс гадна, МНТ-ы зохиогч, хойт монголын хүн байсан тул тэр цагийн хойт монголын аялгуундхи утгаар бичсэн үгсийг орчуулагч, тухайн цагийнхаа өмнөт монголын аялгуундхи утгаар ойлгосноос болсон эндүүрэлт хадмал орчуулгууд ч бий юм. Жишээ нь хойт аялгууны *эсгэл* (агталсан үрээ) гэдэг үгийг өмнөт аялгуундхи утгаар *олон жил унагалаагүй* [хусран гүү] гэж орчуулсан, хойт аялгуундхи *авид* (богино хавирга) гэсэн

үгийг өмнөт аялгуундхи *авид* (гэдэс дотор) гэсэн үгээр орчуулсан (§ 12) гм.

- Худам монгол бичгийн эхээс ташаа уншиж галигласан үгс (жишээ нь, хоёр эгшгийн хоорондхи *γ, g, y* гийгүүлэгч бүхий цугцаас урт эгшиг болсныг зөв сайнаар хийсэн боловч урт эгшиг болоогүй тохиол олон байдгийг нягтлалгүйгээр урт эгшигт үг болгон галигласан, монгол хэлний эр эгшигт үгсийг эм эгшигт үг болгон галиглах хандлага их байдаг (5: 149 т 165), буруу уншиж галигласан үг (ялангуяа оноосон нэр, нэр томъёоны чанартай үгэнд их байгаа) бас арай олон бий нь орчуулгад нөлөөлөхгүй байж хэрхин чадах аж.

Профессор Баяр: «Хажуугийн орчуулгын онцлог нь ер бусын нарийн нямбай, бодот үг нэг бүрд дэс дараалан тайлбар хийснээр зогсохгүй, авиа байвч утга үгүй тэр олон дагаварууд болон сул үгийг ч алдал үгүй орчуулан гаргав (6: 20). Академич Д. Цэрэнсодном: «МНТ-ы үг ухагдахуун бүрийг зөвөөр ойлгоход хажуугийн хятад хадмал орчуулга үнэлж баршгүй ач холбогдолтой юм» гэж үнэлсэнтэй бид нэгэн саналт байна. Гэвч эдгээр сайн үнэлэлт, хятад галиг ба орчуулгын алдаа дутагдлыг шүүмжлэн хэлэлцэхэд саад болохгүй гэж итгэж байна.

Хятад галиг ба орчуулгыг үйлдсэн эрдэмтэд монгол ба хятад хэл бичигт төгс боловсорсон хүмүүс байсан боловч «урт удаан хугацаагаар дотор газар сууснаас» монголын малчин нүүдэлчдийн соёл, сэтгэлгээс ямар нэг хэмжээгээр холдсон, европ хэлнүүдийн идиом хэлцэр хэлбэл «танхимын эрдэмтэд» байсан бололтой.

#### Эшилсэн ном зохиол

1. Rachewiltz I. de, 1972: *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 343 pp.
2. Sumyabaatar B., 1990: *The Secret History of the Mongols*. Transcription (Mongyol-un niyuča tobčiyān. Үсгийн галиг). Улаанбаатар, 965 pp.
3. Дамдинсүрэн Ц., 1990: *Монголын Нууц Товчоо / IV удаагийн хэвлэл*, Улаанбаатар, 255 pp.
4. *Монголын нууц товчоо*, сонгомол эх. Улаанбаатар, 2005, 151 pp. (Abbreviated as МНТ)
5. Gadamba Š., 1990: *Mongyol-un niyuča tobčiyān* (Монгол бичгээр сэргээсэн сийрүүлэг), Ulaanbaatur, 417 pp.
6. Čeringsodnam D., 1990: Dalangtai-yin Čeringsodnam “*Mongyol-un niyuča tobčiyān*”- u orčiyuly-a tayilburi. Begejing, 545 pp.
7. Haenisch, E., 1948: *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 196 pp.
8. Козин, С.А., 1941: *Сокровенное сказание, введение в изучение памятника, перевод. тексты, глоссарии*. М.-Л., 619 pp.
9. Poucha, P., 1955: *Tajná kronika Mongolů*. Praha, 279 pp.
10. Cleaves, F.W., 1982: *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, lxx + 277 pp.
11. Even, M.-D., Pop, R., 1994: *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, Paris, 350 pp.
13. *Altan tobči*, Lubsangdanjin, 1990: The Golden summary which relates briefly the deeds of civil governing established by ancient emperors. The Mongol chronicle of the 17th century. Ulaanbaatur, 177 pp.
15. Хандсүрэн, Ц., 1997: *Цэнд гүн ба Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 646 pp.
17. Lessing, F. D., 1960: *Mongolian-English Dictionary*. Berkeley and Los Angeles, 1217 pp.

18. Цэвэл Я., 1966: *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар, 909 pp.
26. Чоймаа Ш., 2002, “*Монголын Нууц товчоон*”, Лувсанданзаны “*Алтан товч*” эхийн харьцуулсан судалгаа. Улаанбаатар, XII + 187 pp.
27. Lubsangdorji J., 2006, *The Secret History of the Mongols in the mirror of metaphors*, in *Mongolica Pragensia '06*, Prague, pp. 141-161.
28. Lubsangdorji J., 2007: *The Secret History of the Mongols in the mirror of metaphors (2)*, in: *Mongolica Pragensia '07*, Charles University in Prague, p. 55-85, 176 pp.
29. Лувсандорж, Ж., 2007, *Монголын нууц товчоог метафорын толинд харах нь*, in: *Mongolica, An International Annual of Mongolian Studies*, Vol.20 (41), 2007, p. 443, ISSN 1024-3143. Section III: National Language and Literature, p. 74-99.
31. *Qorin nigetü tayilburi toli (1717)*, 1979, Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, Жан жияа кеү, 853 pp.
32. Гаадамба Ш., 1976: *Нууц Товчооны нууцсаас*, Улаанбаатар, 171 pp.
39. Igor de Rachewiltz, 2006: *The Secret History of the Mongols* (Translation with a Historical and Philological Commentary), Vol. I. II. 1349 pp., Leiden- Boston.
44. Vangjil B., 1987, *Köke tülkigür* (Хуучин үгсийн толь), *Öbürmongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriya-a*, 696 pp., ISBN 7 – 5311 – 0269 – 2/Н . 3
45. *qayan-u bičigsen tabun jüil-ün üsüg-iyer qabsuraysan manju ügen-ü toli bičig*, I. II. III., Begejing, 1957, 5048 pp.
50. Лувсанбалдан Х., *Хүлгийн шинж* (Морины шинжийн 28 судрын эмхэтгэл), Улаанбаатар, 1989, 192 pp.
51. Лувсандорж Ж., *Малчны эрдэм* (Ухаант малчдын учиртай үг, эмхтгэл), Улаанбаатар, 1986, 186 pp.
56. Injanasi, *Yeke Yuyan ulus-un manduysan törü-yin köke sudur, terigün debter*, *Öbür Mongyol-un Arad-un Keblel-ün Qoriya-a*, 1979, 682 pp.

#### Хураасан үг:

ж. – жишээ

Ку. – Куракичийн галиг

МНТ – Монголын Нууц Товчоон

Ра. – Рахевилцийн галиг

со-мо. – сонгодог монгол бичиг

ха. – халх аялгуу, одоогийн монгол хэл

хят. – хятад, хятад хэлний